

# Сүнсээр заах нь: Зарим нэгэн хийж болох, болохгүй зүйл

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл А.Максвэлл (1926–2004) Сүнсээр заахын тулд хийж болох, болохгүй зүйлсийг санал болгосон. Үүнд:

Хийж болох зүйлс	Хийж болохгүй зүйлс
1. Зүрх сэтгэлдээ тайван, амар амгалан байж, заах мөчдөө анхаарлаа төвлөрүүл.	1. Мартатай адил, чухал бус зүйлд санаа бүү зов. Иосеф Смит Эмматай маргалдсаныхаа дараа үр дүнтэй ажиллаж чадахгүй байсныг сана. Сүнсийг урих хэцүү. Гэвч бид өөр бусад асуудлаар сэтгэл санаагаа дүүргэсэн үед Сүнс ирэхгүй.
2. Даруу бай, “оюунд чинь би чамд ярих болно” (С ба Г 8:2).	2. Хүмүүст харагдаж, сонсогдохын тулд тэднийг гайхируулахыг бүү хичээ.
3. Үргэлж суралцагчдынхаа нүд рүү харж, тэднийг сонсож бай.	3. Сүнсийг болон суралцагчдынхаа алиныг нь ч сонсох боломжгүйгээр хэтэрхий завгүй зааж болохгүй. Та өөрөө Сүнсийг сонсохгүй байгаа үед ангийнхнаа өөрийг тань сонсоно гэдэгт найдаж болохгүй.
4. Санаанд орж, ой тойнд үлдэх, сүнслэг нөлөө бүхий богино үг хэллэг ашигла.	4. Ойлгоход улам хэцүү болгож, хүнд үг хэллэг бүү ашигла. Хэрвээ Уулан дээрх номлол асар урт байсан бол бид үүнийг үнэлж, талархах байсан уу?
5. Зааж буй зүйлийнхээ агуулгыг мэддэг бай. Энгийн, гол утга санааных нь талаар тунгаан бодож, залбир.	5. Хэн нэгэн ямар нэгэн үр ашигтай зүйл ойлгож авах байх гэж найдан, олон янзын зүйл зааж болохгүй. Гол утга санаа нь тодорхойгүй бол мэдээлэл хүлээн авагчид эргэлзээтэй хоцрох болно.
6. Зааж буй зүйлдээ тохирсон хэрэгжүүлэх арга зам, дүгнэлтийг танилцуул.	6. Хэн ч асуугаагүй асуултад бүү хариул.
7. Сүнслэгээр өдөөгдсөн асуултауд тавь.	7. Асуухаас айх хэрэггүй.
8. Сүнсний нөлөөгөөр удирдуулсан үедээ хэлэх зүйлээсээ суралцах бэлтгэлтэй бай. Ерөнхийлөгч Марион Ж.Ромни хэд хэдэн удаа “Би Ариун Сүнсний нөлөөгөөр ярьж байгаагаа үргэлж мэддэг, учир нь би хэлсэн зүйлээсээ үргэлж ямар нэгэн юм сурдаг” хэмээн хэлэхийг би сонссон <i>Teach Ye Diligently</i> [1975], 304).	8. Суралцагчдынхаа өмнө тунгаан бодохоос бүү эмээ.
9. Хэдэн хором нам гүм байдал үүсгэ. Сүнс үүнийг өөрийн “харагдахгүй зүйлсийн баталгаагаар” хангах болно [Еврей 11:1].	9. Ангид нам гүм болоход сандрах хэрэггүй.
10. Сургаалаар өөрөөр нь заалга. “Бурханы илчилсэн зарчим бүр өөрийн үнэнийг хүмүүний оюунд ухуулах үнэмшлийг агуулж байдаг” ( <i>Teachings of Presidents of the Church: Brigham Young</i> [1997], 72).	10. Сургаал хүлээн авахыг суралцагчдадаа ятгахыг бүү оролд.
11. Гэрчлэлээ зохимжтой бөгөөд тодорхой хуваалц.	11. Зөвхөн “надад гэрчлэл байгаа” гэж бүү хэл.

Нийл А.Максвэлл, “Teaching by the Spirit—‘The Language of Inspiration’” (Хуучин Гэрээний тухай СБС-ийн симпозиум, 1991 оны 8-р сарын 15), 4-5, si.lds.org-оос эш татав.

